**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2026/038/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2026.02.24<br><br>2026 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын<br>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061861 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Азбаяр<br>Утас: 99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 14
**4.1 Ерөнхий зүйл** ........ 14
**4.2 Материаллаг байдал** ........ 15
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 15
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 15
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 15
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 16
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 16
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 17
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2026.02.25 № 2/123

танай__________-ны № __________-т

БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.ЖАВЗАНСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 177,000.0 мянган төгрөгийн төрд учруулсан хохирол барагдуулах албан шаардлага өгч асуудал хуулийн байгууллагад шилжсэн байна.

6426050388

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Дээд шатны захирагчийн дэргэдэх дотоод аудитын алба төсөв захирагчийн бүртгэл, тайланд дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай бөгөөд зөрчил давтагдан гарах эрсдэлтэй байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **422,727,718.02** | **1,077,861,931.20** |
| **33** | **АВЛАГА** | | 177,000,000.00 | 180,512,658.19 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 00.00 | 2,216,926.35 |
| **335** | **Бусад авлага** | | 177,000,000.00 | 178,295,731.84 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | 00.00 | 1,295,731.84 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | | 177,000,000.00 | 177,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | | 245,727,718.02 | 897,349,273.01 |
| **351** | **Түүхий эд материал** | | 15,295,000.00 | 12,042,700.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | 15,295,000.00 | 12,042,700.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | | 00.00 | 636,889,086.00 |
| **354** | **Хангамжийн материал** | | 224,293,076.02 | 242,277,845.01 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 431,120.00 | 468,120.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 28,799,978.74 | 21,232,373.31 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | 563,977.28 | 3,410,951.70 |
| 35450 | Барилгын засварын материал | | 850,000.00 | 970,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 193,648,000.00 | 216,196,400.00 |
| 35600 | Мал амьтад | | 6,139,642.00 | 6,139,642.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **2,356,021,130.91** | **2,749,782,383.31** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | | 2,356,021,130.91 | 2,749,782,383.31 |
| **392** | **Биет хөрөнгө** | | 2,227,671,130.91 | 2,185,920,383.31 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 2,024,155,965.00 | 2,101,730,387.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (461,702,988.49) | (538,626,729.73) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | 432,994,911.00 | 348,430,111.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | (208,674,577.62) | (199,477,981.10) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 352,195,275.93 | 344,138,743.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (247,474,417.60) | (262,983,392.37) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 70,214,304.13 | 56,342,304.13 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (40,877,667.26) | (42,621,466.71) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 423,791,855.00 | 534,211,465.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | (122,751,529.18) | (161,023,057.84) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | 5,800,000.00 | 5,800,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | 128,350,000.00 | 563,862,000.00 |
| 39301 | Програм хангамж | | 780,000.00 | 780,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (702,000.00) | (780,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 128,272,000.00 | 563,862,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **2,778,748,848.93** | **3,827,644,314.51** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **25,463,680.34** | **29,158,663.74** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | 25,463,680.34 | 29,158,663.74 |
| **413** | **Өглөг** | | 25,463,680.34 | 29,158,663.74 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 4,505,430.34 | 4,227,008.89 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 00.00 | 711,054.85 |
| **4136** | **Бусад өглөг** | | 20,958,250.00 | 24,220,600.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 20,168,250.00 | 20,535,500.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | | 790,000.00 | 3,685,100.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **2,753,285,168.59** | **3,798,485,650.77** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | 2,753,285,168.59 | 3,798,485,650.77 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 525,709,281.22 | 525,709,281.22 |
| 51101 | Өмч: - төрийн | | 525,709,281.22 | 525,709,281.22 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | | 1,955,438,817.62 | 3,000,639,299.80 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 1,955,438,817.62 | 1,975,006,767.62 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 00.00 | 1,025,632,532.18 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 272,137,069.75 | 272,137,069.75 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **2,778,748,848.93** | **3,827,644,314.51** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Тодруулга** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | | **2,510,340,450.43** | **2,672,064,444.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **609,487,308.93** | **1,398,007,146.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 609,487,308.93 | 1,398,007,146.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 200,000.00 | 620,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 200,000.00 | 620,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **1,900,853,141.50** | **1,274,057,298.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 54,395,541.50 | 11,806,198.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 25,252,951.50 | 2,482,973.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 29,142,590.00 | 9,323,225.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | 1846457600.00 | 1262251100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 1,846,457,600.00 | 1,262,251,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | | **1,828,868,365.63** | **1,615,062,911.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **1,828,868,365.63** | **1,615,062,911.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 1,781,825,074.97 | 1,557,811,433.63 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 667,291,869.81 | 815,862,346.97 |
| 210101 | Үндсэн цалин | | 396,961,826.52 | 444,106,637.13 |
| 210102 | Нэмэгдэл | | 222,832,359.56 | 309,389,248.39 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 37,616,000.00 | 43,636,161.45 |
| 210104 | Урамшуулал | | 9,881,683.73 | 18,730,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 83,419,471.66 | 101,866,249.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 56,930,205.47 | 67,150,962.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 6,622,352.40 | 8,473,882.01 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 3,251,645.25 | 4,082,981.03 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 3,305,056.15 | 4,074,230.53 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 13,310,212.39 | 18,084,193.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 64,886,870.51 | 82,800,302.69 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 13,180,788.61 | 20,407,818.53 |
| 210302 | Түлш, халаалт | | 51,706,081.90 | 62,392,484.16 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 180,279,421.13 | 70,391,812.01 |
| 210401 | Бичиг хэрэг | | 10,548,490.00 | 5,126,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 46,728,809.62 | 38,675,028.58 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 3,770,330.00 | 4,819,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 20,600,000.00 | 12,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 24,594,250.00 | 9,770,983.43 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 74,037,541.51 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 17,369,100.00 | 5,911,380.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 9,140,000.00 | 788,080.00 |
| 210604 | Урсгал засвар | | 8,229,100.00 | 5,123,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 16,326,000.00 | 9,370,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | 170,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 16,156,000.00 | 9,370,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 50,400,448.00 | 13,776,973.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 43,598,545.00 | 8,517,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 800,000.00 | 800,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 659,475.00 | 1,287,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 549,568.00 | 439,896.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | 238,700.00 | 54,712.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 960,500.00 | 580,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 3,593,660.00 | 2,096,965.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 701,851,893.86 | 457,832,369.68 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 506,173,640.00 | 215,007,690.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 195,678,253.86 | 242,824,679.68 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 47,043,290.66 | 57,251,478.27 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 28,676,320.50 | 650,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 1,500,000.00 | 650,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 23,876,320.50 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 3,300,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | 18,366,970.16 | 56,601,478.27 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 18,366,970.16 | 56,601,478.27 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | | **681,472,084.80** | **1,057,001,532.10** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | 00.00 | 31,368,999.92 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 00.00 | 31,368,999.92 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | 00.00 | (31,368,999.92) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | | **681,472,084.80** | **1,025,632,532.18** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | | **1,901,053,141.50** | **1,274,677,298.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **200,000.00** | **620,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 200,000.00 | 620,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | | 200,000.00 | 620,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 200,000.00 | 620,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **1,900,853,141.50** | **1,274,057,298.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 54,395,541.50 | 11,806,198.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 25,252,951.50 | 2,482,973.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 29,142,590.00 | 9,323,225.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | 1,846,457,600.00 | 1,262,251,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 1,846,457,600.00 | 1,262,251,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | | **1,403,373,237.50** | **1,266,527,398.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **1,403,373,237.50** | **1,266,527,398.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **1,356,329,946.84** | **1,209,325,919.73** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 668,424,216.90 | 816,478,162.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 337,235,322.80 | 398,583,092.32 |
| 210102 | Нэмэгдэл | | 248,572,263.53 | 358,153,653.09 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 42,106,768.61 | 43,611,101.09 |
| 210104 | Урамшуулал | | 40,509,861.96 | 16,130,315.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 77,343,449.33 | 103,245,543.08 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 50,639,523.33 | 70,192,143.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 6,809,100.00 | 8,262,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 3,485,200.00 | 4,131,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 3,472,000.00 | 4,131,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 12,937,626.00 | 16,527,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 60,954,844.61 | 83,724,679.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 13,180,788.61 | 20,036,463.68 |
| 210302 | Түлш, халаалт | | 47,774,056.00 | 63,688,216.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 68,441,794.00 | 59,272,390.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 6,249,890.00 | 3,661,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 28,024,924.00 | 36,317,940.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 3,416,330.00 | 4,227,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 20,600,000.00 | 12,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 10,150,650.00 | 3,065,250.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 16,260,600.00 | 5,542,580.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 4,220,000.00 | 788,080.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | | 12,040,600.00 | 4,754,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 15,476,000.00 | 9,880,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 15,476,000.00 | 9,880,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 222,913,718.00 | 13,901,073.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 214,564,815.00 | 8,319,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 800,000.00 | 800,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 659,475.00 | 1,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 579,268.00 | 439,896.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | 209,000.00 | 54,712.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 2,507,500.00 | 1,190,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 3,593,660.00 | 2,096,965.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 226,515,324.00 | 117,281,491.97 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 226,515,324.00 | 117,281,491.97 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **47,043,290.66** | **57,201,478.27** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 28,676,320.50 | 600,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 00.00 | 600,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 23,876,320.50 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 4,800,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | 18,366,970.16 | 56,601,478.27 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 18,366,970.16 | 56,601,478.27 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | | **497,679,904.00** | **8,149,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | | **497,679,904.00** | **8,149,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **497,679,904.00** | **8,149,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | 497,679,904.00 | 8,149,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 497,679,904.00 | 8,149,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | | **(497,679,904.00)** | **(8,149,900.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **525,709,281.22** | **272,137,069.75** | **1,955,438,817.62** | 2,753,285,168.59 |
| D01 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **525,709,281.22** | **272,137,069.75** | **1,955,438,817.62** | 2,753,285,168.59 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 19,567,950.00 | 19,567,950.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **525,709,281.22** | **272,137,069.75** | **1,975,006,767.62** | 2,772,853,118.59 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,025,632,532.18 | 1,025,632,532.18 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **525,709,281.22** | **272,137,069.75** | **3,000,639,299.80** | 3,798,485,650.77 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,279,643,600.00 | 1,214,575,027.76 | 65,068,572.24 | 94.9 |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,223,078,000.00 | 1,213,955,027.76 | 9,122,972.24 | 99.3 |
| Орон нутгийн төсвөөс | 1,223,078,000.00 | 1,213,955,027.76 | 9,122,972.24 | 99.3 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 56,565,600.00 | 620,000.00 | 55,945,600.00 | 1.1 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 620,000.00 | 380,000.00 | 62.0 |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 55,565,600.00 | 0.00 | 55,565,600.00 | 0.0 |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,279,643,600.00 | 1,214,575,027.76 | 65,068,572.24 | 94.9 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,279,643,600.00 | 1,214,575,027.76 | 65,068,572.24 | 94.9 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,278,643,600.00 | 1,213,975,027.76 | 64,668,572.24 | 94.9 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 826,361,000.00 | 816,478,162.00 | 9,882,838.00 | 98.8 |
| Үндсэн цалин | 403,282,000.00 | 398,583,092.32 | 4,698,907.68 | 98.8 |
| Нэмэгдэл | 360,797,800.00 | 358,153,653.09 | 2,644,146.91 | 99.3 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 42,208,000.00 | 43,611,101.09 | - 1,403,101.09 | |
| Урамшуулал | 20,073,200.00 | 16,130,315.50 | 3,942,884.50 | 80.4 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 103,294,000.00 | 103,245,543.08 | 48,456.92 | 100.0 |
| Тэтгэврийн даатгал | 70,240,600.00 | 70,192,143.08 | 48,456.92 | 99.9 |
| Тэтгэмжийн даатгал | 8,262,600.00 | 8,262,600.00 | - | 100.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 4,131,800.00 | 4,131,800.00 | - | 100.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 4,131,800.00 | 4,131,800.00 | - | 100.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 16,527,200.00 | 16,527,200.00 | - | 100.0 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 106,468,000.00 | 83,724,679.68 | 22,743,320.32 | 78.6 |
| Гэрэл, цахилгаан | 21,700,000.00 | 20,036,463.68 | 1,663,536.32 | 92.3 |
| Түлш, халаалт | 84,768,000.00 | 63,688,216.00 | 21,079,784.00 | 75.1 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 65,014,000.00 | 58,431,670.00 | 6,582,330.00 | 89.9 |
| Бичиг хэрэг | 6,950,000.00 | 3,661,700.00 | 3,288,300.00 | 52.7 |
| Тээвэр, шатахуун | 37,100,000.00 | 35,597,220.00 | 1,502,780.00 | 95.9 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,464,000.00 | 4,107,500.00 | 356,500.00 | 92.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 12,000,000.00 | 12,000,000.00 | 0.00 | 100.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,500,000.00 | 3,065,250.00 | 1,434,750.00 | 68.1 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,956,600.00 | 12,904,400.00 | 1,052,200.00 | 92.5 |
| Багаж, техник, хэрэгсэл | 8,200,000.00 | 8,149,900.00 | 50,100.00 | 99.4 |
| Урсгал засвар | 5,756,600.00 | 4,754,500.00 | 1,002,100.00 | 82.6 |
| **Томилолт, зочны зардал** | 13,900,000.00 | 9,880,000.00 | 4,020,000.00 | 71.1 |
| Дотоод албан томилолт | 13,900,000.00 | 9,880,000.00 | 4,020,000.00 | 71.1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,650,000.00 | 13,581,573.00 | 3,068,427.00 | 81.6 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,000,000.00 | 8,000,000.00 | 0.00 | 100.0 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 800,000.00 | 800,000.00 | 0.00 | 100.0 |
| Даатгалын үйлчилгээ | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 850,000.00 | 439,896.00 | 410,104.00 | 51.8 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 500,000.00 | 54,712.00 | 445,288.00 | 10.9 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,800,000.00 | 1,190,000.00 | 610,000.00 | 66.1 |
| Газрын төлбөр | 3,700,000.00 | 2,096,965.00 | 1,603,035.00 | 56.7 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 133,000,000.00 | 115,729,000.00 | 17,271,000.00 | 87.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 133,000,000.00 | 115,729,000.00 | 17,271,000.00 | 87.0 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,000,000.00 | 600,000.00 | 400,000.00 | 60.0 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 1,000,000.00 | 600,000.00 | 400,000.00 | 60.0 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,000,000.00 | 600,000.00 | 400,000.00 | 60.0 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 | - | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 0.00 | - | |

## 2.6 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баян-Овоо сумын ЗДТГ нь "Сумын Засаг Даргын Тамгын газрын чиг үүргийг хэрэгжүүлэх, хуриулагчтай хамт олныг бүрдүүлж чанартай, хүртээмжтэй төрийн үйлчилгээг иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөн буй орчинд уян хатан зохицож чаддаг бөгөөд идэвхтэй, санаачилгатай, манлайлагч менежер бүхий цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн, бусдад үлгэрлэхүйц жишиг байгууллага байх" эрхэм зорилготой тус байгууллага нь үндсэн ажилтан 17, гэрээт ажилтан 4, нийт 21 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай , Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 07/25 дугаар удирдамжийн дагуу Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны эхний хагас жилийн тээвэр шатахууны зарцуулалт, хөрөнгө ашиглалтын үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч 2025 оны 07 дугаар сарын 23-аас 2025 оны 07 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэж нийт 21,069.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, 1,188.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,000.0 мянган төгрөгийн албан шаардлага өгч, 17,880.8 төгрөгийн зөвлөмжийг хүргүүлж ажилласан бөгөөд хэрэгжилтийг Баян-Овоо сумын ЗДТГ-ын даргын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 157 албан бичгээр биелэлтийг ирүүлсэн биелэлт 100 хувьтай.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Овоо сумын ЗДТГ-ын2025 оны санхүүгийн тайланг дагуу Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,048,895.5 мянган төгрөг буюу 37.7 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 177,000.0 | 180,512.7 | 3,512.7 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 245,727.7 | 897,349.3 | 651,621.6 |
| Үндсэн хөрөнгө | 3,438,204.3 | 3,955,295.0 | 517,090.7 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,082,183.2) | (1,205,512.6) | (123,329.4) |
| **Нийт хөрөнгө** | 2,778,748.8 | 3,827,644.3 | 1,048,895.5 |

| | | | |
|---|---|---|---|
| Өр төлбөр | 25,463.7 | 29,158.7 | 3,695.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,753,285.2 | 3,798,485.7 | 1,045,200.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 2,778,748.8 | 3,827,644.3 | 1,048,895.5 |

Авлагын дансны үлдэгдэл 180,512.7 мянган төгрөг болж 3,512.7 мянган төгрөгөөр өссөн нь ЭМНДШ-д 221.0 мянга, үйлдвэрчний эвлэлд 565.9 мянга, хувь хүнээс авах авлага 1,430.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол 177,000.0 мянган төгрөгийн өмнөх оны авлага нь прокурорын газарт шалгагдаж байгаа гэж толилуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 879,349.3 мянган төгрөг болж 651,621.6 мянган төгрөгөөр өссөн нь Бусад хангамжийн материалын данс 22,548.4 мянга, Дуусаагүй үйлдвэрлэлд ЗДТГ-ыг 2 дугаар байрны их засварын ажлыг 636,889.1 бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна. Төсвийн хөрөнгөөр худалдан авалтаар 159,898.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй 99,143.5 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч 232,001.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 13,857.5 мянган төгрөгийг данс хооронд шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,955,295.0 мянган төгрөг болж 517,090.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 8,149.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, Үнэ төлбөргүй 653,205.3 мянган төгрөгийн хөрөнгийг бусад эх үүсвэрээс, 6,600.0 мянган төгрөгийг хөрөнгө акталсан хөрөнгө үнэлж орлогод бүртгэсэн бол 81,600.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 62,264.2 мянган төгрөгийг акталж данснаас хассан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 29,158.7 мянган төгрөг болж 3,695.0 мянган төгрөгөөр өссөн ба энэ ХХОАТ-т 4,227.0 мянга, гэрэл цахилгаанд 371.4 мянга, шатахуун 339.7 мянга малын тэжээлд 18,200.0 мянга, бусад байгууллагад төлөх өглөг 7,654.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,798,485.7 мянган төгрөг болж 1,045,200.5 мянган төгрөгөөр өссөний 1,025,632.5 мянган төгрөг нь тайлант оны үр дүн байна.

Тайлант онд тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох ХХК-ийн "Аклоус" санхүүгийн программ, Payroll цалингийн программ ашигладаг бөгөөд төсвөөс 382.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,061,939.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 232,889.3 мянган төгрөг нэмж 1,294,829.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,294,829.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| хөтөлбөр арга хэмжээ | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 973,500.6 | 932,131.93 | 56,554.07 | 94.3 |
| 80106 | Баг, хорооны ҮАЗардал | 160,143.00 | 154,114.09 | 6,028.91 | 96.2 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 1,000.00 | 600.00 | 400.00 | 60.0 |
| 81102 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 100,000.00 | 88,329.85 | 11,670.15 | 88.3 |
| 82212 | Хур хог хаягдал, орчны бохирдол | 12,000.00 | 12,000.00 | 0.00 | 100.0 |
| 82310 | Гамшгаас сэргийлэх сургалт,сургалт | 33,000.00 | 27,399.15 | 5,600.85 | 83.0 |
| | НИЙТ | 1,279,643.6 | 1,214,575.03 | 80,253.97 | 93.8 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

1. Хоолны зардлыг 1 өдрийн 8.0 мянган төгрөгөөр тооцож, 52,800.0 мянган төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 43,232.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.
2. Тайлант онд Малчин тариаланчдын зөвлөгөөнд 3,397.0 мянган төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 3,180.0 мянга, “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургалтад 6,048.2 мянган төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 5,970.2 мянга, Эх хэлний өдөрлөг сургалтад 750.0 мянган төгрөг төлөвлөж бүрэн зарцуулсан байна.
3. Байгууллага бүтэц, орон тоог анх 26 орон тоотой 887,703.2 мянган төгрөг баталж, тайлант оны дундуур 3 орон тоо бууруулж 826,360.1 мянган төгрөгийн төсөв тодотгон баталсан ба гүйцэтгэлээр 816,478.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шатахууны зардлыг зардлыг 33,900.0 мянган төгрөгөөр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган баталсан байна.

Шатахууны зардлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж “Сод Монгол” ХХК-тай шатахуун нийлүүлэх гэрээг байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-

ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 8 дугаар тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сонгосон суурь үзүүлэлт болох 2025 оны батлагдсан төсөв 1,294,829.00 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 12.948.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Батлагдсан төсвийг зориулалт ангиллын дагуу сортолж горим сорил гүйцэтгэхэд Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн асуудал гараагүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг байршуулахаас 5 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгээгүй

### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 502,349.3 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага өгсөн ба хэрэгжилтийг хянаж, үнэлсэн.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 277,682.1 | 1 | 277,682.1 | 100% |
| Албан шаардлага | 1 | 31,167.2 | 1 | 31,167.2 | 100% |
| Албан шаардлага | 1 | 16,500.0 | 1 | 16,500.0 | 100% |
| Албан шаардлага | 1 | 130,000.0 | 0 | 0 | 100% |
| Албан шаардлага | 1 | 47,000.0 | 0 | 0 | |
| **Нийт дүн** | **5** | 502,349.3 | **3** | 325,349.3 | 60% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Өмнөх 2024 оны дутуу шийдвэрийн хэрэгжилтийн хэрэгжилтийг авч үзэх шаардлагатай
- Гүйцэтгэлийн аудитын хэрэгжээгүй албан шаардлагыг ТТЗ-аар хэрэгжилтийг авч үзэх шаардлагатай

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,993.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “зөрчилгүй” дүгнэлт өгөхөөр шийдвэрлэсэн.

### 5.1 Албан шаардлага

5.1.1. Урсгал засварын зардалд 2025 оны 07 дугаар сарын 01нд, 2025 оны 07 дугаар сарын 06-ны өдрүүдэд 2 удаагийн гүйлгээгээр 3,675.0 мянган төгрөг зарцуулсан боловч юу хийж гүйцэтгэсэн талаарх ажлын тайлан байхгүй анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Урсгал засвараар хийсэн ажлын тайлан, биелэлтийг анхан шатны баримт, бусад нотлох баримтаар үнэн зөв бүрэн гаргаж тайланг эхний хагас жилд багтаан ирүүлэх.

5.1.2. Засаг даргын нөөц хөрөнгөөс Чадварлаг багш-Чанартай сургалт хөтөлбөрийн сурагчдын цүнх 13,248.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1-д заасан “Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна” гэсэн заалтыг зөрчсөн зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Засаг даргын нөөц хөрөнгөөс журамд заагаагүй арга хэмжээг зориулалт бусаар зарцуулдаг байдлыг таслан зогсоох.

5.1.3. Бүрдэн нуурын тахилгад тахилгад зориулан төсвөөс 1,070.0 мянган төгрөг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т заасан “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 25 дугаар зүйлийн 25.10-т заасан “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар шашны шинж чанартай тахилга хийх, буян номын хандив өргөх зэрэг үйл ажиллагаанд зарцуулдаг байдлыг таслан зогсоох.

5.1.4. Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудаст төсөв гүйцэтгэлтэй холбоотой 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх албан шаардлага өгөв.

Дээрх шийдвэрүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Урсгал засварын зардалд 2025 оны 07 дугаар сарын 01нд, 2025 оны 07 дугаар сарын 06-ны өдрүүдэд 2 удаагийн гүйлгээгээр 3,675.0 мянган төгрөг зарцуулсан боловч юу хийж гүйцэтгэсэн талаарх ажлын тайлан байхгүй анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. | 1 | 3,675.0 | | | 1 | 3,675.0 | | |
| Засаг даргын нөөц хөрөнгөөс Чадварлаг багш-Чанартай сургалт хөтөлбөрийн сурагчдын цүнх 13,248.0 мянган төгрөгийг зарцуулсан. | 1 | 13,248.0 | | | 1 | 13,248.0 | | |
| Бүрдэн нуурын тахилгад тахилгад зориулан төсвөөс 1,070.0 мянган төгрөг зарцуулсан. | 1 | 1,070.0 | | | 1 | 1,070.0 | | |
| **Нийт дүн** | **3** | **17,993.0** | **0** | **0** | **3** | **17,993.0** | **0** | **0** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудаст төсөв гүйцэтгэлтэй холбоотой 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Дүн | | | | | | | | |

------------oOo------------